



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/319

Эрдэнэт

Эрх шилжүүлэх, хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3/б/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны Ээлжит IV хуралдааны 02, 2017 оны Ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2017 оны А/306 дугаар захирамжаар батлагдсан “Өрхийн тариалалтыг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд шаардагдах 105000000 /Нэг зуун таван сая/, эргэн төлөгдөх 23500000 /Хорин гурван сая таван зуун/ төгрөгийг хавсралтаар баталж, захиран зарцуулах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзийд/-т шилжүүлсүгэй.


2. “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

3. Шаардагдах 105000000 /Нэг зун таван сая/ төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын  
22-ны өдрийн 1/329 дугаар захирамжийн хавсралт

**“ӨРХИЙН ТАРИАЛАЛТЫГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ**

д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөв / мянган төгрөг/	Зохион байгуулах хэлбэр	Тайлбар
1	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэхэд эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, борлуулалтыг дэмжих	Төмсний үр бэлтгэх /5000 кг, Каурта, гала сорт/	40000.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	Төмсний үрийг эргүүлэн үрээр авч нөөц бүрдүүлнэ.
2		Нарийн ногооны үр бэлтгэх / Шар лууван, хүрэн манжин, шар манжин, сонгино/	9500.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	
3	Хүлэмжийн талбайг нэмэгдүүлэх чиглэлээр хөнгөлттэй нөхцлөөр хүлэмж олгох ажлыг орон нутагт зохион байгуулах	Зуны хүлэмж /6x10 буюу 60 м <sup>2</sup> /	19500.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	Иргэдэд олгохдоо гэрээ байгуулан 50 хувийг буцаан төсөвт төвлөрүүлнэ.
4		Зуны хүлэмж /6x20 буюу 120 м <sup>2</sup> /	27500.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	
5	Дээрх арга хэмжээний хүрээнд сургалт, зөвлөгөө, мэргэжлийн арга зүйгээр хангах, угсралт, хүргэлтийн зардал		8500.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	
	<b>Нийт дүн</b>		<b>105000.0</b>		
<b>Эргэн төлөгдөх зардал</b>					
1	Чацарганы суулгац	5000 ш	12500.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	
2	Хүлэмж	5 ш	11000.0	Төсөл арга хэмжээний хүрээнд	
	<b>Нийт дүн</b>		<b>23500.0</b>		